

# “ДАГНАСАН ШҮҮХИЙН ТОГТОЛЦОО: ХҮҮХДИЙН ЭРХ АШИГ БА ГЭР БҮЛ” НЭЭЛТИЙН ҮГ

/2025 оны 06-р сарын 25 өдөр/



Өнөөдрийн арга хэмжээнд хүрэлцэн ирсэн эрхэм зочид, төлөөлөгч, хурлын оролцогч та бүхний өглөөний амар амгаланг айлтгая.

Монгол Улс шүүхийн шинэтгэлийн үзэл баримтлалд үндэслэн ирэх жилд 3 дахь дагнасан шүүхээ байгуулах бэлтгэл ажлын хүрээнд, энэхүү “*Дагнасан шүүхийн тогтолцоо: Хүүхдийн эрх ашиг ба гэр бүл*” олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж байна.

Бидний нийгмийн, ялангуяа хууль зүйн олон асуудлын шалтгаан гэр бүлээс үүдэж, үр дагавар нь гэр бүлд нөлөөлдөг. Тийм ч учраас Хүний эрхийн түгээмэл тунхаглал (§16.3 - Гэр бүл бол нийгмийн жам ёсны буюу суурь бүлэг бөгөөд нийгэм, төрийн хамгаалалтад байна) зэрэг олон улсын баримт бичгүүдэд гэр бүл нийгмийн бүлгийнхээ хувьд төрийн хамгаалалтад байх ёстойг тодотгодог. Канад, Австрали, Япон, Герман (ХБНГУ), Франц (БНФУ), Солонгос (БНСУ), Сингапур зэрэг

цөөнгүй улсад гэр бүлийн дагнасан шүүх, тухайлсан танхим, эсвэл шүүгч ажиллаж гэр бүлийн маргааныг дагнан шийдвэрлэж байна.

Манай улсын хувьд, хүүхэд хамгааллын чиглэлээр 40 гаруй олон улсын эрх зүйн баримт бичигт нэгдэж орсон. Гэр бүл, хүүхдийн хэргийн дагнасан шүүх байгуулах явдал нь өөрсдийн эрх зүйн тогтолцоог илүү хүнлэг, боловсронгуй болгохоос гадна олон улсын өмнө өгсөн амлалтаа биелүүлж буй хэрэг мөн. Тухайлбал, Насанд хүрээгүй хүмүүсийн талаар шүүн таслах ажиллагаа явуулахтай холбогдуулан НҮБ-аас гаргасан стандартын 1.4 дэх хэсэгт “Насанд хүрээгүйчүүдийн шүүхийн тогтолцоог улс орнууд үндэсний хөгжлийн үйл явцын салшгүй бүрэлдэхүүн хэсэг гэж ойлгох ёстой” тухай заасан байдаг.<sup>1</sup> Ийм шүүхийн тогтолцоо нь Хүүхдийн эрхийн конвенцын 3-р дугаар зүйлд тусгагдсан “хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангах”-ад өндөр ач холбогдолтой.

Монгол Улсад 2023 онд Иргэний хэргийн анхан шатны шүүхэд гэр бүлийн эрх зүйн 5913 хэрэг шийдэгдсэн бол 2024 онд 6520 болон өсөж, нийт шийдэгдсэн хэргийн 10-аад (8.8434) хувийг эзэлжээ. Шийдвэрлэгдсэн тоон эзлэхүүнээрээ нийт хэргийн 3-т эрэмбэлэгдэж байна. 2024 онд 1675 насанд хүрээгүй хүн гэмт хэрэгт холбогдсон нь нийт бүртгэгдсэн гэмт хэрэг үйлдэгсдийн (25291) 6.62 хувийг эзэлж, 209 нь шүүхээр ял шийтгүүлсэн бол мөн онд хүүхэд оролцсон гэмт хэрэг 1373, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 1559 бүртгэгдсэн нь өмнөх оноос ойролцоогоор 10 хувь өсжээ.

Энэ мэт олон тоон үзүүлэлтээс гэр бүл, хүүхдийн хэрэг маргааныг дагнан шийдвэрлэх шүүх байгуулах нь хүүхдийн хууль ёсны эрх ашгийг зохих ёсоор хамгаалах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох онцлогт нийцсэн нөхцөлийг бүрдүүлэх, шүүхийн ачааллыг зөв хуваарилах, гэр бүлийн хариуцлагыг дээшлүүлэх, эвлэрүүлэн зуучлалын үр нөлөөг ахиулах зэрэг олон талын ач холбогдолтой болохыг харж болно.

---

<sup>1</sup>1.4 Насанд хүрээгүйчүүдийн шүүхийн тогтолцоог тухайн улсын үндэсний хөгжлийн үйл явцын салшгүй бүрэлдэхүүн хэсэг болгон ойлгох ёстой бөгөөд энэ нь бүх насанд хүрээгүй хүүхдэд зориулсан нийгмийн шударга ёсны цогц тогтолцооны хүрээнд хэрэгжих учиртай. Ингэснээр залуу үеийг хамгаалахад болон нийгэмд энх тайван, эмх журмыг сахин хадгалахад хувь нэмэр оруулна.

Энэ утгаараа бидний хувьд тойргийн дагнасан шүүх байгуулагдаж байгаа нь ахиц боловч цаашид олон улсын туршлага, хөгжилд зэрэгцэж очих, дотооддоо дагнасан шүүхийн манлайллыг түүчээлэх өндөр хариуцлага хүлээгдэж байгааг цохон тэмдэглэе. Энэхүү шүүхийн хэргийн харьяаллаас гадна, олон улсын гэр бүлийн маргаан дахь шүүхийн харьяаллын асуудлаас эхлээд бусад улсын шүүхтэй харилцан ойлголцох шаардлагатай процессын онцлог асуудлууд нэмэгдэж байгаа талаар Ази, Номхон далайн бүсийн Ерөнхий шүүгчдийн бага хурлаар онцолж байсныг дуулгая.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн бодлого” хэрэгжүүлэхээр тусгасан нь энэхүү дагнасан шүүхийг хөгжүүлэхэд эрх мэдэл хоорондын хамтын ажиллагааг дөтлөх боломжийг нэмэгдүүлж буй.

Процессын хувьд хувийн ба нийтийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх учраас шүүхээс хэргийг шийдвэрлэх үндэслэл болох нөхцөл байдлыг тогтоохын тулд шалгах ажиллагаа явуулах, нотлох баримт цуглуулах, нотолгооны онцлог үзэл баримтлалыг мөрдөх, сонирхогч этгээдийн нэхэмжлэлээр хэрэг үүсгэх, гэр бүл цуцлахад хүүхэдтэй холбоотой бусад асуудлыг заавал хамтад нь шийдвэрлэх, мэргэшсэн сэтгэл зүйч ажиллуулах зэрэг өвөрмөц зохицуулалтыг хэрэгжүүлэх нь гарцаагүй. Энэ талаар тухайлсан хуулийн төслүүдийг санал авахаар Улсын дээд шүүхэд ирүүлсэн. Өнөөдрийн хурлын нэг үр дүн нь тус төслүүдийг улам боловсронгуй болгох санал, санаачилга гаргахад чиглэнэ.

Энд онцолж жишээ татахад, зарим бүсийн шинжтэй олон улсын байгууллагаас (Европын Комиссын сайд нарын зөвлөл) Хүүхдэд ээлтэй шударга ёсны тогтолцооны үндсэн шинжүүдийг:

- Хүртээмжтэй;
- Насанд нь нийцсэн;
- Шуурхай;
- Хариуцлагатай, нягт нямбай;
- Хувийн болон гэр бүлийн амьдралын халдашгүй байдлыг хүндэтгэдэг;

- Хэргийг нь шийдэхэд хүүхдийн өөрийн оролцоог хангах, шүүхийн процессыг ойлгож ухамсарлах эрхийг нь баталгаажуулах зэргээр (нийт 9 шинж) тодорхойлсон.

Мөн хүүхдийн оролцоог хангаж, ашиг сонирхлыг нь эрхэмлэх, эрхэм чанар-нэр төрийг нь дээдлэх, ялгаварлахгүй байх гэсэн үндсэн зарчмуудыг манай улсад байгуулагдах шүүх хөдөлбөргүй баримтлах ёстой. Шүүгдэгч, гэр бүл цуцлах маргааны оролцогч зэргээр хууль зүйн процесст оролцоно гэдэг хүүхдийн хувьд ойлгоход хүнд, зарим талаар айж эмээх сэтгэгдэл төрүүлэхүйц насанд хүрэгчдийн ертөнцөд хөл тавьж буй явдал гэдгийг ч бид мартаж болохгүй.

Цаашид энэхүү шүүхийг дэлхийн жишигт нийцүүлж, хөгжүүлэхэд:

**Нэгдүгээрт**, шүүгч, шүүхийн албан хаагчид бүгд өөрсдийн ажлын онцлогийг бүрэн ухамсарласан, чадварлаг, мэргэшсэн байхыг нэн түрүүнд шаардана.

**Хоёрдугаарт**, салбар дундын хамтын ажиллагааг оновчтой хөгжүүлэх ёстой. Хүүхдийн ба гэр бүлийн сэтгэл зүйч, мэргэшсэн шинжээчид, хүүхэд хамгааллын байгууллагууд нягт уялдаж ажиллах шаардлагатай.

**Гуравдугаарт**, шүүхийн идэвхтэй (active) буюу хязгаарлалттай (restraint) байх асуудал маргаантай байдаг ч гэр бүл, хүүхдийн хэрэг дээр зөвхөн хөндлөнгөөс шийдээд орхихоос илүүтэй, анхаарал хандуулж илүү хариуцлагатай ажиллах хэрэгтэй болно.

**Дөрөвдүгээрт**, Институтийнхээ хувьд уг дагнасан шүүх салбарын бодлогын нэгэн оролцогч боловч шинэ тутам бий болж байгаа утгаараа бодлого боловсруулах түвшинд идэвхтэй оролцдог байх ёстой. Энэ хүрээнд Шүүхийн Ерөнхий Зөвлөл, Шүүхийн Сахилгын Хороонд төлөөллөө оролцуулах нь зүйтэй.

Ингээд эцэст нь, энэхүү хурлыг хамтран зохион байгуулж буй **Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага, Ханнс-Зейделийн сангийн хамт олон болон алс холоос хүрэлцэн ирж мэдлэг туршлагаа хуваалцаж буй ХБНГУ, Нидерланд, Япон, БНСУ, Бүгд Найрамдах Турк улс, АНУ**-ын эрдэмтэн, шүүгч, мэргэжил нэгт нөхөд та бүхэнд талархлаа илэрхийлье.

Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

Хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье.

-----oO-----

## OPENING REMARKS AT THE INTERNATIONAL CONFERENCE “SPECIALIZED COURT: CHILDREN’S RIGHTS AND FAMILY”

/June 25th, 2025/



Distinguished guests, representatives, and participants of the conference, good morning to you all.

In line with Mongolia’s judicial reform concept, and as part of the preparatory work to establish its third specialized court next year, Mongolia is organizing this international conference entitled “Specialized court: Children’s Rights and the Family”.

Many social issues—particularly legal ones—originate within the family, and their consequences ultimately affect the family as well. For this reason, international instruments such as the Universal Declaration of Human Rights (§16.3: The family is the natural and fundamental group unit of society and is entitled to protection by society and the State) emphasize that the family, as a social unit, must be protected by the State. In several countries, including Canada, Australia, Japan, Germany, France, South Korea, and Singapore, family disputes are resolved by specialized family courts, dedicated chambers, or specialized judges.

Mongolia has acceded to more than 40 international legal instruments on child protection. Establishing a specialized court for family and child cases not only humanizes and further refines our legal system but also constitutes the fulfillment of Mongolia's international commitments. For example, paragraph 1.4 of the United Nations standards relating to the administration of justice concerning juveniles states that juvenile justice systems should be understood by States as an integral part of their national development process. Such a judicial system is of particular importance for ensuring the best interests of the child, as enshrined in Article 3 of the Convention on the Rights of the Child.

In Mongolia, 5,913 family law cases were resolved by first instance civil courts in 2023, increasing to 6,520 cases in 2024, accounting for approximately 10 percent (8.8434%) of all resolved cases. By volume, family cases ranked third among all categories of cases adjudicated. In 2024, 1,675 juveniles were implicated in criminal offenses, representing 6.62 percent of all registered offenders (25,291), of whom 209 were convicted by courts. In the same year, 1,373 crimes involving children and 1,559 crimes committed as a result of domestic violence were registered, reflecting an increase of approximately 10 percent compared to the previous year.

These statistical indicators clearly demonstrate that establishing a specialized court to adjudicate family and child-related cases is of multifaceted importance. Such a court would ensure the proper protection of children's lawful rights and interests, create procedures tailored to the specific characteristics of children's participation in judicial proceedings, distribute judicial workload more appropriately, strengthen family responsibility, and enhance the effectiveness of mediation.

In this context, while the establishment of a circuit-level specialized court represents tangible progress, it must be emphasized that there is a high level of responsibility to further align with international standards and to lead the development of specialized courts domestically. Beyond jurisdictional issues, challenges are also increasing in relation to procedural matters requiring cooperation with foreign courts, including questions of jurisdiction in international family disputes—an issue highlighted at the Conference of Chief Justices of the Asia-Pacific region.

The Government of Mongolia's 2024–2028 Action Program includes the implementation of a policy tailored to family and demographic characteristics, which creates greater opportunities to strengthen inter-institutional cooperation in developing this specialized court.

From a procedural perspective, because such courts adjudicate both private-law and public-law disputes, they will inevitably require distinctive regulatory arrangements. These include conducting fact-finding measures to establish the circumstances underlying judicial decisions, collecting evidence, applying specialized evidentiary approaches, initiating cases based on applications by interested parties, resolving child-related matters jointly when adjudicating divorce cases, and engaging professional psychologists. Draft laws addressing these matters have been submitted to the Supreme Court of Mongolia for consultation, and one of the key outcomes of today's conference is expected to be constructive proposals and initiatives to refine these drafts further.

By way of example, certain regional international bodies, such as the Council of Ministers of the European Commission, have identified core characteristics of a child-friendly justice system, including that it be:

- Accessible;
- Age-appropriate;
- Prompt;
- Diligent and responsible;
- Respectful of private and family life; and
- Ensuring the child's right to participate, understand, and be heard in judicial proceedings (among a total of nine characteristics).

In addition, fundamental principles—such as ensuring children's participation, prioritizing their best interests, respecting their dignity and honor, and preventing discrimination—must be strictly observed by the courts to be established in Mongolia. We must also bear in mind that participation in legal proceedings, whether as a defendant or as a party to a family dispute, places a child in an adult-oriented legal environment that can be difficult to comprehend and, in some cases, intimidating.

Looking ahead, to develop this court in line with international standards:

**First**, it is essential that judges and court staff fully understand the specific nature of their work and possess the requisite competence and specialization.

**Second**, effective cross-sectoral cooperation must be developed, involving child and family psychologists, specialized experts, and child protection agencies working in close coordination.

**Third**, while the extent to which courts should adopt an active versus restrained role remains debated, in family and child cases, courts must go beyond mere adjudication and engage with heightened attention and responsibility.

**Fourth**, institutionally, although this specialized court is one participant in the broader sectoral policy, its newly established nature requires it to play an active role in policy development. In this regard, representation within the Judicial General Council and the Judicial Disciplinary Committee would be appropriate.

Finally, I would like to express my sincere appreciation to the **International Development Law Organization and the Hanns Seidel Foundation** for co-organizing this conference, as well as to the scholars, judges, and professional colleagues from **Germany, the Netherlands, Japan, South Korea, the Republic of Türkiye, and the United States** who have traveled from afar to share their knowledge and experience.

Thank you all for your attention.

I wish the conference every success.

-----oOo-----